Ноён Жадамбын Энхбаярын хэлсэн үг
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд

Сайд нарын 25 дугаар бага хурал
Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр
2026 оны 9 дүгээр сарын 29, Монгол Улс, Улаанбаатар хот

Азийн хөгжлийн банкны Ерөнхийлөгч, ноён Масато Канда,

Эрхэм хүндэт төлөөлөгчдийн тэргүүнүүд, Сайд нар,

Хөгжлийн түнш байгууллагуудын эрхэм хүндэт төлөөлөгчид,

Хатагтай, ноёд оо,

Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс та бүхнийг Улаанбаатар хотноо халуун дотноор угтан авч, КАРЕК хөтөлбөрийн 25 дугаар Сайд нарын бага хуралд хүрэлцэн ирсэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Өнөөдөр бид КАРЕК хөтөлбөрийн 25 жилийн ойг “25 жилийн түншлэл - Ирээдүйг хамтдаа цогцлоох нь” уриан дор тэмдэглэж байна.

Хорин таван жилийн өмнө эхэлсэн КАРЕК хөтөлбөр эдүгээ бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны чухал механизм болон өргөжжээ. КАРЕК-ийн бүс нутаг 1.8 тэрбум хүн амтай, ойролцоогоор 20 их наяд ам.долларын эдийн засгийг бүрдүүлж, дэлхийн нийт ДНБ-ий 16.3 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн 25 жилд КАРЕК хөтөлбөрийн хүрээнд 60 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт гишүүн орнуудад хийгдэж, тээврийн коридор, хил дамнасан холболт, эрчим хүч, худалдааны хамтын ажиллагааны бат бөх суурь тавигджээ.

Гишүүн орнуудын хоорондох бүс нутаг доторх худалдааны эзлэх хувь 2001 онд 1.9 хувь байсан бол 2024 онд 4.9 хувь болж, харилцан хөрөнгө оруулалтын эзлэх хувь 0.5 хувиас 3.3 хувь болж өссөн байна. Мөн өдөрт 3 ам.доллароос бага орлогоор амьдардаг хүн амын эзлэх хувь 2001 онд 54.5 хувь байсан бол 2025 онд 17 хувь болж буурсан нь КАРЕК хөтөлбөр бүс нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсныг харуулна.

Эрхэм хүндэт төлөөлөгчид өө,

Хатагтай, ноёд оо,

Өнөөдөр геополитикийн тодорхойгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт, технологи, цахим шилжилтийн хурдацтай өөрчлөлт зэрэг томоохон сорилтууд бидний хамтын ажиллагаанд шинэ хандлага, шаардлагыг тавьж байна.

Тэдгээрийг даван туулахад харилцан итгэлцэл, бодлогын уялдаа, үр дүнд чиглэсэн түншлэл урьд урьдынхаас чухал болж байна. Нийтлэг эрх ашгаа түшиглэн, улс орнуудынхаа давуу тал, нөөц боломжийг нэгтгэж, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой өсөлт, гадаад цочролд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх нь бидний хамтын хариуцлага байх учиртай.

Бүс нутгийн холболтыг зам, тээвэр, эрчим хүчний дэд бүтцээр хязгаарлалгүй, цахим сүлжээ, мэдлэг, инновацын солилцоогоор өргөжүүлэх шаардлагатай. Биет болон цахим холболтыг уялдуулан хөгжүүлснээр худалдаа, хөрөнгө оруулалтын саад тотгор буурч, бизнес эрхлэгчдийн зах зээлд хүрэх боломж нэмэгдэн, хөгжлийн үр өгөөж иргэдэд илүү хүртээмжтэй хүрнэ. Иймд цахим хөгжлийн зөрүүг багасгах, хүний нөөцийн ур чадварыг ахиулах,

найдвартай, аюулгүй цахим дэд бүтцийг бий болгох хамтын хүчин чармайлт бүс нутгийн өрсөлдөх чадварын чухал тулгуур болно.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, шороон шуурга бүс нутгийн бүх улсуудад хил хязгааргүй нөлөөлж байна. Монгол Улс энэ онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг **зохион байгуулсан** туршлагадаа тулгуурлан, газрын доройтол, цөлжилттэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааг КАРЕК-ийн хүрээнд эрчимжүүлэхийг санал болгож байна.

КАРЕК 2030 стратегийн хэрэгжилтийн хүрээнд цаашдын хамтын ажиллагаа маань зөвхөн холболтыг нэмэгдүүлэхээс гадна түүний үр өгөөжийг эдийн засгийн бодит боломж болгон хувиргах, бүс нутгийн сөрөн тэсвэрлэх байдлыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэхэд чиглэх нь зүйтэй гэж бид үзэж байна.

Өнөөдрийн хурлаар бид хилийн боомтын шинэчлэл, худалдааг хөнгөвчлөх, цахим холболт, чухал ашигт малтмалын өртгийн сүлжээ, санхүүгийн зах зээлийн хамтын ажиллагааг хэлэлцэж, эдгээрийг хэрэгжүүлэх тодорхой алхмуудаа тогтоох болно. Мөн **Сайд нарын хамтарсан мэдэгдэл**-ийг баталж, КАРЕК хөтөлбөрийн дараагийн шатны хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлно гэдэгт итгэлтэй байна.

Чухал ашигт малтмалын хувьд Монгол Улс **зэс, газрын ховор элемент** зэрэг баялгаа зөвхөн түүхий эдээр бус, боловсруулсан бүтээгдэхүүнээр бүс нутгийн өртгийн сүлжээнд нийлүүлэх зорилготой. Үүнд шаардлагатай хөрөнгө оруулалт, технологи, тээвэр ложистикийн хамтын ажиллагааг дэмжихийг түншүүддээ уриалж байна.

Эрхэм хүндэт Сайд нар аа,

Далайд гарцгүй, дэлхийн хоёр том эдийн засгийн дунд оршдог Монгол Улсын хувьд бүс нутгийн холболт нь хөгжлийн чухал нөхцөл юм. Манай улс 2003 онд КАРЕК хөтөлбөрт нэгдсэнээс хойш тус хөтөлбөрийн хүрээнд 19 төсөл, 1.5 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаар авто зам, хилийн боомт, логистикийн дэд бүтцээ хөгжүүлсэн.

Цаашид бид “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан хил дамнасан төмөр замын холболт зэрэг Засгийн газрын томоохон төслүүдтэй уялдуулан зөвхөн дамжин өнгөрөх тээврийн чиглэлээр зогсохгүй, худалдаа, тээвэр, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг хооронд нь холбосон бүс нутгийн зангилаа болох зорилт тавьж байна.

Энэ хүрээнд Монгол Улс 2026 оны 6 дугаар сард КАРЕК-ийн дамжин өнгөрөх тээврийн дэвшилтэт систем, Мэдээллийн нэгдсэн солилцооны /CATS/ICE/ туршилтын төсөлд нэгдсэн. Мөн манай Санхүүгийн зохицуулах хороо КАРЕК-ийн Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн форумыг анх удаа даргалахаар боллоо. Эдгээр нь манай улс бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож буйн илэрхийлэл юм.

Өнгөрсөн 25 жил тууштай хамтын ажиллагаа бодит үр дүнгээ өгдгийг харууллаа. Ирэх 25 жилд бид энэхүү бат сууринд түшиглэн, улс орнуудынхаа хөгжил дэвшлийг харилцан тэтгэж, хамтын амжилтын шинэ хуудсыг нээнэ гэдэгт итгэлтэй байна.

КАРЕК хөтөлбөрийг 25 жилийн турш тууштай дэмжиж ирсэн Азийн хөгжлийн банк, хөгжлийн түншүүд болон бүх гишүүн орнуудад чин сэтгэлийн талархал илэрхийлж, өнөөдрийн хэлэлцүүлэгт та бүхний санал, туршлага, идэвхтэй оролцоонд найдана.

Ингээд КАРЕК хөтөлбөрийн 25 дугаар Сайд нарын бага хурлыг нээснийг мэдэгдье.

Баярлалаа.